



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Амар даатгал” ХХК-ийн “Ажиллагедын хариуцлагын даатгал”-ын хавсралтад дурдсан бүтээгдэхүүнийг бүртгэсүгэй.
2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Амар даатгал” ХХК /Т.Батзул/-д үүрэг болгосугай.
3. Тус бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Амар даатгал” ХХК /Т.Батзул/, актуарч /Д.Уранцэцэг/-д тус тус анхааруулсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

F:\ajil 2019\Blank\Togtool.doc

000648



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Амар даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Ажиллагсдын хариуцлагын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Хариуцлагын даатгал
4.	Даатгалын зүйл	Ажиллагсад нь хөдөлмөрийн гэрээнд заасан үндсэн ажил, үүргээ гүйцэтгэх явцад санамсар болгоомжгүйн улмаас буюу ажлын ур чадвар дутагдсанаас ажил олгогчийн өмнө хүлээх эд хөрөнгийн хариуцлага
5.	Даатгалын эрсдэл	Ажиллагсдын санамсар болгоомжгүй үйлдэл
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	12 бүлэг, 136 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ЗТ-19/04-006 тоот шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Д.Уранцэцэг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Үйл ажиллагааны газрын захирал Я.Энхбаяр, Хуулийн зөвлөх Г.Энхцэцэг, даатгалын менежер Ч.Энхтүвшин